



МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

СОЁМБОМ ЭДЭЭ

№40 /254/ 2022.02.28

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

Цаг үе, үйл явдал

“ЦЭРГИЙН НИЙТЛЭГ ДҮРМҮҮД”-ИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦҮҮЛЖ БАЙНА



Монгол Улсын “Цэргийн нийтлэг дүрмүүд”-ийн шинэчилсэн найруулгын төслийн нэгдсэн хэлэлцүүлэг болж байна. Хэлэлцүүлэгт БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, Төрийн цэргийн байгууллагын төлөөллүүд болон Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын захирагч нар оролцож байна.

ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга бригадын генерал С.Ганбямба хэлэлцүүлгийг нээж хэлсэн үгэндээ “ЗХЖШ-ын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг, мөн түүнтэй уялдсан дэд ажлын хэсэг энэхүү шинэчилсэн

найруулгын төслийг боловсруулсан юм. Батлан хамгаалахын сайдаас өгсөн чиглэлийн дагуу эцэслэсэн найруулгын төсөлд Төрлийн цэргийн командлалууд, Төрийн цэргийн байгууллагууд, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын саналыг дахин авч, яаманд хүргүүлээд байна. БХЯ-ны СБТГ санаачилга гарган ЗХЖШ-тай хамтраад өнөөдрийн хэлэлцүүлгийг зохион байгуулж байна. 2019 онд батлагдсан “Цэргийн нийтлэг дүрмүүд”-ийн хувьд, Төрийн цэргийн байгууллагууд болон Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын эрхзүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага байгаа нь харагдсан. Ийм учраас дүрмийн төслийг шинэчлэн боловсруулахаар ажилласан. Дүрмийн төслийг Батлан хамгаалахын сайд, Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барина. Уг дүрмүүдийг чамбайруулах, үйлчлэх хугацааг нь уртасгах, хэрэгжих боломжийг бодитой байлгах зорилгоор энэхүү хэлэлцүүлгийг хийж байна. Та бүхэн өөрсдийн санал бодлыг илэрхийлж, хэлэлцүүлэгт идэвхтэй оролцохыг уриалж байна” хэмээв.

Энэ үеэр ЗХЖШ-ын ХШҮГ-ын дарга, ажлын хэсгийн гишүүн хурандаа Ж.Өсөхбаяр Монгол Улсын “Цэргийн нийтлэг дүрмүүд”-ийн шинэчилсэн найруулгын төслийн ерөнхий танилцуулгыг хийсэн юм.

Танилцуулгад өмнөх онуудад батлагдсан “Цэргийн нийтлэг дүрмүүд” нь тухайн үеийн Зэвсэгт хүчний үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн баримт бичиг байж чадсан боловч улс төр, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хууль эрхзүйн орчны өөрчлөлтүүд нь Зэвсэгт хүчний үйл ажиллагаанд мөн өөрчлөлт авчирч байгааг дурдсан. Түүнчлэн орчин үеийн нийгмийн харилцаа, хууль тогтоомжийн өөрчлөлт шинэчлэлтэд нийцсэн эрх зүйн орчныг бүрдүүлэхийн тулд “Цэргийн нийтлэг дүрмүүд”-ийг шинэчлэх хэрэгцээ шаардлага үүссэн гэдгийг онцолсон юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-8	-22

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
32	24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,873.00	2,877.0
EUR	3,215.0	3,245.0
CNY	454.00	456.00
RUB	35.00	36.50
JPY	24.80	25.00
KRW	2.39	2.41

ЗУРХАЙ



ХАВРЫН ТЭРГҮҮН ХАР БАР САРЫН ДОЛООН УЛААН ХАР ХУЛГАНА ӨДӨР

Үс засуулбал:
Хэрүүл тэмцэл ирнэ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
07.35-18.34
Барилдлага:
Идэр
Шүтэн барилдлага:
Тийн мэдэхүй
Суудал: Гал

ХОЁРДУГААР САРЫН ШИЛДГҮҮД ТОДОРЛОО



Зэвсэгт хүчний 032 дугаар анги

2021-2022 оны сургуулийн жилийн “Цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөө”-ний дагуу 2 дугаар сарын “Сахилгын дүнгийн хурал”-аа хийж, “Цэргийн тангараг” давтлаа.

Сахилгын дүнгийн хурлаар ангийн тэргүүний хамт олон, алба хаагчдыг шалгаруулах журмын дагуу 2 дугаар сарын шилдгүүдээ шалгаруулсан юм. “Сарын тэргүүний хамт олон”-оор Ажиллагааны удирлагын тасаг, “Сарын тэргүүний офицер”-оор ХҮТР-ын салааны захирагч дэслэгч Г.Анхбаяр, “Сарын тэргүүний ахлагч”-аар ЦЦР-ын

ротын ахлагч сургагч ахлагч Т.Бямбацогт, “Сарын тэргүүний ажилтан алба хаагч”-аар Ахуйн үйлчилгээний хэсгийн үсчин О.Одтуяа, “Сарын тэргүүний тамирчин”-аар ХҮТР-ынн буудагч байлдагч Г.Үүрийнцолмон, “Сарын тэргүүний түрүүч”-ээр ХҮТР-ын тасгийн захирагч, ариун цэврийн зааварлагч түрүүч Н.Содбаяр, “Сарын тэргүүний байлдагч”-аар ХХТР-ын буудагч байлдагч Ж.Тэмүүжин нар тус тус шалгарав. Дээрх алба хаагчдыг ангийн захирагчийн тушаалаар баяр хүргэж сайшаасан бөгөөд албаны үүргээ үлгэр жишээчээр биелүүлж байгаа тухай ар гэрийнхэнд нь талархлын захидал илгээх юм.

Ахлах дэслэгч Т.ДЭЛГЭРМАА



ҮР ДҮНТЭЙ СУРГАЛТ БОЛОВ



Монгол цэргийн музей

ҮБХИС-д хичээллэж буй “Хүний хөгжлийн менежер” мэргэжлүүлэх сургалтын хүрээнд “Цэргийн улс төр, соёл, хүмүүжлийн ажилтны нэгдсэн эвлэл” төрийн бус байгууллага, Монгол цэргийн музейтэй хамтран “Музейн сан хөмрөг, үзмэрийг бие бүрэлдэхүүний хөгжил төлөвшилд ашиглах нь” сэдэвт хичээлийг энэ сарын 24-ний өдөр Монгол цэргийн музейн үзүүллийг түшиглэн зохион байгуулсан юм. Дээрх сэдвээр бэлтгэл дэд хурандаа Л.Гантөмөр сургалт явуулсан бол “Цэргийн алба хаагчидтай зохиох соён гэгээрүүлэх ажлын зорилго, хэлбэр, арга зүйн шинэчлэл” сэдвээр бэлтгэл хурандаа Б.Жуваа, “Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл сонин, сэтгүүлийг цэргийн алба хаагчдын оюун санааны хөгжилд ашиглах арга зүй” сэдвээр бэлтгэл хурандаа Г.Нямдорж нар сургалт явуулж, тухайн сэдвийн хүрээнд англи, салбарууд болон музей, хэвлэл мэдээллийн байгууллагуудад тулгамдаж буй асуудлууд, цаашид хэрхэн хамтран ажиллах болон цэргийн алба хаагчдын сэтгэл зүйн төлөвшилд музей, хэвлэл мэдээллийн байгууллагуудын



үүрэг оролцоог өргөжүүлэх арга замыг эрэлхийлсэн, ахмад ажилтнуудын туршлага, ажлын арга барилаас суралцсан онцлог сургалт боллоо.

Сургалтад хамрагдагсад Монгол цэргийн музейг үзэж, сургалтаар мэдсэн зүйлээ анги, салбартаа хэрэгжүүлэх өндөр сэтгэгдэлтэй, онолын мэдлэгээ амьдралд хэрэгжүүлэх хүсэл тэмүүлэлтэй буцлаа.

Монгол цэргийн музейн боловсролын ажилтан Г.АЛТАНЗУЛ

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН 2,271,548 /69.8%/	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН 2,172,909 /66.8%/	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН 1,023,271 31,5% 102,635 /3,2%/
--	---	--

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 8293 +112	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 105	ЭДГЭРСЭН 8069
------------------------------	----------------------------	------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 435,994,531

Эдгэрсэн

Нийт: 366,533,745

Нас барсан

Нийт: 5,968,034



Цахим шууданд

АЛБА СУРТАЛЧЛАХ ӨДӨРЛӨГӨӨР ...

Зэвсэгт хүчний 014 дүгээр анги

2021-2022 оны сургуулийн жилийн сэтгэл зүйн хангалтын төлөвлөгөөний дагуу алба, салбар сурталчлах аяныг Замын ротын хамт олон долоо хоногийн хугацаатайгаар зохион байгууллаа. Энэ хүрээнд ангийн бие бүрэлдэхүүний дунд "Олс таталт"-ын аварга шалгаруулах тэмцээн, "Дээлтэй Монгол" өдөрлөг, ХЦАХ-дын дунд "Шатар"-ын тэмцээнүүдийг үе шаттайгаар зохион байгуулав. Дээрх тэмцээнүүдэд бие бүрэлдэхүүн идэвх санаачилгатай оролцсон бөгөөд "Олс таталт"-ын төрлөөр тэргүүн байрт Штаб, дэд байрт Холбоо, гутгаар байрт Материал хангалтын албаны баг тамирчид шалгарлаа. "Дээлтэй Монгол" өдөрлөгийн хүрээнд "Багийн мэндчилгээ", "Тайзны алхаа", "Бие биелгээ" зэрэг цогцолбор тэмцээнийг зохион байгуулсан бөгөөд тэргүүн байрт дэд ахлагч Б.Өсөхбаяр, С.Батсүрэн, дэд байрт ахлах ахлагч М.Эрдэнэбаяр, дэслэгч Р.Билэг, гутгаар байрт ахлах дэслэгч Г.Амгалан,



н.Дэлгэрмаа нар шалгарсан байлдагч Г.Баяр, дэд байрт юм. Түүнчлэн хугацаат цэргийн алба хаагчдын дунд зохион байгуулсан шатрын тэмцээний тэргүүн байрт С.Ган-Эрдэнэ, удаах байрт Б.Еркебулан нар тэргүүлээ. **Дэслэгч Р.БИЛЭГ**

"ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ-ЭРТЭЧ МОНГОЛ" АЯНД НЭГДЭВ



Зэвсэгт хүчний 011 дүгээр анги

Тус ангийн хамт олон "Биеийн тамир-эрүүл мэнд", "Илүүдэл жингүй-Эртэч монгол" аянд нэгдэж өглөө бүр 07-08 цагийн хооронд

ангий спорт зааланд фитнес дасгалыг хийж байна.

Тэргүүн ахлагч Б.Пүрэвсүрэн

ХЭЭРИЙН СУРГУУЛИЙН БЭЛТГЭЛЭЭ БАЗААЖ БАЙНА

Зэвсэгт хүчний 120 дугаар

Тус ангийн бие бүрэлдэхүүн 2021-2022 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу энэ сарын 22-24-ний өдрүүдэд Байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулийн бэлтгэл ажлыг Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвд базааж байна. Бэлтгэл ажлын хүрээнд тактик, тусгай тактик, мэргэжлийн бэлтгэл, материал хэрэгслийн бэлтгэл, эмнэлгийн бэлтгэл, сэтгэл зүйн бэлтгэл ажлыг ханган сургалтын төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.

Дэслэгч Э.НОМИН



СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын төв штабт дараах ажлын байранд үүрэг гүйцэтгэх (P-3, P-4, P-5) сонгон шалгаруулалтад хамрагдах сонирхолтой офицеруудыг сонгон шалгаруулалтад урьж байна. Үүнд:

- Эрүүл мэндийн хангалтын хэлтсийн дарга P-5
- Бодлого, номлол хариуцсан ахлах офицер P-5
- Цэргийн асуудал хариуцсан ахлах офицер P-5
- Ахлах холбогч офицер P-5
- Цэргийн асуудал хариуцсан офицер P-4
- Төлөвлөлтийн офицер P-4 (бодлого төлөвлөлт)
- Төлөвлөлтийн офицер P-4 (хүч бүрдүүлэлт)
- Бодлого, номлол хариуцсан офицер P-4
- Дүн шинжилгээний офицер P-4
- Хуулийн офицер P-4
- Цэргийн зөвлөхийн орлогчийн тусгай

туслах P-4

- Төлөвлөлтийн офицер P-3 (бодлого төлөвлөлт)
- Дүн шинжилгээний офицер P-3

Сонгон шалгаруулалтад хамрагдах хүсэлтэй цэргийн алба хаагчид

2021 онд шинээр батлагдсан "ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦУУЛАХ БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ"-ыг судлан танилцаж, журмын 3.3, 3.6, НҮБ-ын штабын ажилтанд тавигдах шаардлагыг хангасан байх ба ЗХЖШ-ын АУГ-ын Энхийг дэмжих ажиллагааны хэлтэст 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн дотор харьяа командлал, газар, хэлтсээр дамжуулан саналаа ирүүлнэ. Холбогдох албан тушаалын жагсаалт, тавигдах шаардлага, дэлгэрэнгүй мэдээллийг psod@mil.gov.mn цахим мэйл хаягаар болон 3203, 92096622 утсаар холбогдож тодруулж болно.

ЗХЖШ-ЫН АУГ-ЫН ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд 2022-2023 онд үүрэг гүйцэтгэх штабын ажилтан, цэргийн мэргэжилтний сонгон шалгаруулалтыг 2022 оны 03 дугаар сарын 21-ээс 25-ны өдрүүдэд зохион байгуулна.

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй цэргийн алба хаагчид 2021 онд батлагдсан "ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦУУЛАХ БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ" –тай танилцаж, НҮБ-ын штабын ажилтан, цэргийн мэргэжилтэнд тавигдах шаардлагыг хангасан байх ба ЗХЖШ-ын АУГ-ын Энхийг дэмжих ажиллагааны хэлтэст доорх материалыг бүрдүүлэн 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн дотор ирүүлнэ. Үүнд:

- Харьяа анги, байгууллага, төрлийн цэргийн командлал болон ЗХЖШ-ын бүтцийн нэгжийн удирдлагын зөвшөөрсөн цохолттой хувийн өргөдөл;
- Ажил байдлын тодорхойлолт
- Жолооны үнэмлэхийн хуулбар;
- Цэргийн ажиглагч, штабын офицерын сургалт, дамжаа дүүргэсэн сертификатын хуулбар;
- Сүүлийн 3 сарын дотор авхуулсан 4х6 хэмжээтэй цээж зураг 2 хувь.
- Товч судалгаа
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт

Анги	Албан тушаал	Цол	Овог, нэр	Нас	Боловсрол, цэргийн мэргэжил, дамжаа	Анги, байгууллагад ажилласан байдал	Одоогийн албан тушаалд томилогдсон огноо	ЭДА-нд үүрэг гүйцэтгэсэн байдал

Жич: Шаардлагатай нэмэлт мэдээллийг АУГ-ын ЭДАХ-ийн psod@mil.gov.mn цахим шуудангаар болон /3203, 92115982, 92096622/-тэй холбогдож тодруулж болно. "ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦУУЛАХ БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ" –тай ЗХЖШ-ын цахим хуудасны эрх зүйн булан буюу <https://gsmf.gov.mn/gsmf/cat/60> холбоосоор, англи хэлний бичгийн болон ярианы шалгалтын сэдвүүдтэй <https://gsmf.gov.mn/gsmf/onePost/2220> холбоосоор орж танилцана уу.

ЗХЖШ-ЫН АУГ-ЫН ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС

"МӨНГӨН ӨВӨЛ" ӨДӨРЛӨГИЙН ХҮРЭЭНД ...

Зэвсэгт хүчний 110 дугаар анги

Тус ангийн бие бүрэлдэхүүн цасны баяр буюу "Мөнгөн өвөл" өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр нийгмийн хариуцлагын хүрээнд "Хөшөөтийн даваа", "Амарбаясгалант" хийдийн хөшөө дурсгалт газрын орчин тойрныг цэвэрлэж, соёлын үнэт өв болон түүхийн дурсгалт газрууд, "Амарбаясгалант" хийдийг бие бүрэлдэхүүнд танилцууллаа.

Мөн үүнээс гадна бие бүрэлдэхүүний дунд "Цасны сүмо", "Олс таталт", "Хөгжөөнт буухиа", "Цасны бүжиг"-ийн тэмцээнийг зохион



байгуулж бие бүрэлдэхүүний авхаалж самбааг сорьж, хамт олны идэвх, гар нийлэмжтэй ажиллагааг бүрдүүлээ. **Ахлах дэслэгч Д.ДАВААЖАРГАЛ**

Таны сонрт

УРАЛДААНД УРЬЖ БАЙНА

ЦНДС-ийн Агаарын цэргийн тэнхимийн 30 жилийн ойн ажлын хүрээнд өөрийн төгссөн сургууль, хуучин нэрээрээ АДХЦ-ийн тэнхим, Зенит артиллери, Зенитийн пуужин, Радиотехник, Радиоэлектроник, Нисэхийн мэргэжлээрээ бахархсан 8 мөрт шүлгийн уралдааныг зохион байгуулж байна. Шүлгийг файлаар болон бичгээр ирүүлж болно.

Уралдааныг 2022 оны 3 сарын 17-ны өдөр ҮБХИС-ийн ЦНДС, Агаарын цэргийн тэнхимд шалгаруулна. Зохиогч материалаа Dungaа.tse@gmail.com электрон хаягаар илгээхдээ овог нэр, холбогдох утасны дугаараа заавал бичсэн байна. Мөн бичлэн авч ирж болно.

АГААРЫН ЦЭРГИЙН ТЭНХИМ